

Оюутнууд сургалтын төлбөрөө төлөхөд илүү хялбар боллоо

Оюутнууд сургалтын төлбөрөө SISI системд нэвтрэн зөвхөн онлайнаар төлдөг байсан бол нэмээд аль ч банкаар үйлчлүүлэн төлбөр төлөх боломжтой боллоо. Ингэхийн тулд ердөө салбар сургуулийнхаа харилцах дансны дугаар, SISI системд нэвтрэх хэрэглэгчийн нэрээ мэддэг байхад хангалттай.

Энэ үйлчилгээний давуу тал нь:

- Оюутан заавал карт ашиглах шаардлагагүй.
- Оюутан аль ч банкаар үйлчлүүлэн төлбөрөө төлж болно.
- Оюутан банк хоорондын гүйлгээ хийх боломжтой.
- Оюутан өөрийн биеэр банкны теллерээр үйлчлүүлэхээс гадна төлбөр төлөх бусад хэлбэрүүдийг ашиглаж болно. Үүнд: интернет банк, смарт банк, mobile банк гэх мэт.
- Оюутны төлсөн төлбөр SISI дэх дансны үлдэгдэлд нэмэгдэн орно.
- Төлбөр төлсний дараа оюутан SISI системд нэвтрэн орж, SISI дэх дансны үлдэгдлээр хичээлээ баталгаажуулна.

Үйлчилгээнд тавигдах шаардлага:

- Оюутан салбар сургуулийнхаа Хаан болон Голомт банкин дахь харилцах дансны дугаарыг мэддэг байх.
- Оюутан SISI системд нэвтрэх хэрэглэгчийн нэр буюу SISI ID-гаа мэддэг байх.
- SISI ID-г зөвхөн латин үсгээр бичнэ.
- Аль ч төрлийн гүйлгээ хийхэд **гүйлгээний утга хэсэгт SISI ID-г хамгийн эхэнд бичнэ** Жишээ нь:

Гүйлгээний утга: **14B1SAS1234**

Гүйлгээний утга: **14B1SAS1234 Овог Нэр** / SISI ID-ний араас зай аваад дурын текст бичиж болно/

Анхааруулга:

- Уг үйлчилгээг сонгон төлбөрөө төлсний дараа SISI системд нэвтрэн орж SISI дэх дансны үлдэгдлээр **хичээлээ баталгаажуулах** шаардлагатай.
- Нэг сая төгрөг доторх Голомт банкны дансанд хийсэн банк хоорондын гүйлгээ манай системд шууд (real time) бүртгэгдэх бол Хаан банкны дансанд хийсэн банк хоорондын гүйлгээ 10 минутын дараа бүртгэгдэх болно.
- Нэг сая төгрөгөөс дээш банк хоорондын гүйлгээ ажлын өдрүүдэд 16 цагаас өмнө 15-30 минутын хугацаанд шилждэг бол 16 цагаас хойшхи гүйлгээ дараагийн ажлын өдрийн 10 цагт багтан шилжин орно.

МУИС-ийн Хаан банк, Голомт банкны харилцах данс

№	Сургуулийн нэр	Харилцах банкны нэр, дансны дугаар			
		Голомт банк		Хаан банк	
		Дансны нэр	Дансны дугаар	Дансны нэр	Дансны дугаар
1	ХШУИС	МУИС-ХШУИС	8115006179	Монгол Улсын Их Сургууль	5041339528
2	ШУС-БУС	МУИС-Шинжлэх ухааны сургууль	8115006325	Монгол Улсын Их Сургууль	5041123767
3	ШУС-НУС	МУИС НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ	8115006329	Монгол Улсын Их Сургууль	5041123790
4	ШУС-ХУС	МУИС ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ	8115006331	МУИС ШУС-ХУСалбар	5041123789

5	ОУХНУС	МУИС- ОУХНУСургууль	8115006181	Монгол Улсын Их Сургууль	5041339517
6	Хууль зүйн сургууль	МУИС-Хууль зүйн их сургууль	8115006180	Монгол Улсын Их Сургууль	5041339506
7	Бизнесийн сургууль	МОНГОЛ-УЛСЫН ИХ СУРГУУЛЬ	8115006330	Монгол Улсын Их Сургууль	5041123756
8	Орхон сургууль		-	Монгол Улсын Их Сургууль	5093076065
9	Завхан сургууль		-	МУИС-ийн Завхан сургууль	5495409830